



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/552

Эрдэнэт

### Үзэсгэлэн худалдаанд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 б, 29.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах” аймгийн дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод Мишээл экспо худалдааны төвд зохион байгуулагдах “Намрын ногоон өдрүүд-2017” улсын нэгдсэн арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг I, бэлтгэл ажлын төлөвлөгөөг II, үзэсгэлэн худалдаанд оролцоход шаардагдах зардлыг III хавсралтаар тус тус баталсугай.


2. Үзэсгэлэн худалдаанд оролцуулах хүнс үйлдвэрлэгч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч бүлэг, хоршоодын бэлтгэлийг сайтар хангуулж зохион байгуулалттай оролцохыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр нарт үүрэг болгосугай.

3. “Намрын ногоон өдрүүд-2017” улсын нэгдсэн арга хэмжээнд оролцоход шаардагдах 3268000 /гурван сая хоёр зуун жаран найман мянган/ төгрөгийг “Алтан намар-2017” орон нутгийн шинэ ургацын ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Дээрх ажлын бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилт, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны  
 09 дүгээр сарын 19-ны өдрийн  
 АБС-2 дугаар захирамжийн III хавсралт

**“НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2017” УЛСЫН НЭГДСЭН АРГА  
 ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

Д/д	Ажил арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Шаардагдах шатахуун /л/	Нэгжийн үнэ /төг/	Бүгд үнэ /мян.төг/	Тайлбар
<b>Нэг. “Эрүүл Монгол Хүнс-2016” үзэсгэлэн арга хэмжээ</b>							
1	Хаяг, анонс, лого, танилцуулгын эх бэлтгэх, хэвлүүлэх	м <sup>2</sup>	24	-	9000	216.0	1 ширхэг анонсоор тооцов.
2	Орон нутгийн бүтээгдэхүүний танилцуулга самбар, гарын авлага бэлтгэн хэвлүүлэх	км	300	-	1500	450.0	
3	“Портер” машинаар хүнсний бүтээгдэхүүн, хөргүүр, лангуу, тавиур, ширээ, сандал авч явах, ирэхэд шаардагдах шатахуун	ш	2400	432	1750	756.0	3 ачааны машинаар явна.
4	Малгай, энгэрийн тэмдэг бэлтгэн хэвлүүлэх		20	-	22000	440.0	Нийт оролцогчдын малгай, энгэрийн тэмдэг
<b>Зардал /мян.төг/</b>						<b>1862.0</b>	
<b>Хоёр. “Алтан намар-2016” үзэсгэлэн арга хэмжээ</b>							
1	Хаяг, анонс, лого, танилцуулгын эх бэлтгэх, хэвлүүлэх	м <sup>2</sup>	32	-	9000	288.0	
2	Орон нутгийн бүтээгдэхүүний танилцуулга самбар	ш	2	-	55.0	110.0	
3	“Портер” машинаар хүнсний бүтээгдэхүүн, хөргүүр, лангуу, тавиур, ширээ, сандал авч явах, ирэхэд шаардагдах шатахуун	км	3200	576	1750	1008.0	4 ачааны машинаар явна.
<b>Зардал /мян.төг/</b>						<b>1406.0</b>	
<b>Нийт зардал /мян.төг/</b>						<b>3268.0</b>	

**Тайлбар:** 1. “Эрүүл Монгол хүнс-2017”, “Алтан намар-2017” үзэсгэлэн арга хэмжээ нь “Мишээл экспо” худалдааны төвд 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулагдана